



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



World Learning
EDUCATION | DEVELOPMENT | EXCHANGE



LEAD MONGOLIA
Leaders Advancing Democracy

БИДНИЙ НӨЛӨӨ
2016-2018



Энэхүү тайланг америк ард түмний дэмжлэг, Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн тусламжтайгаар бэлтгэв. Уг тайлангийн агуулгыг World Learning байгууллага хариуцах бөгөөд Америкийн Нэгдсэн Улсын Засгийн Газар, Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн байр суурийг илэрхийлэхгүй болно.

Эрхэм уншигч танд ардчиллыг бэхжүүлэх, шинэ үеийн манлайлагчдыг бэлтгэх зорилготой LEAD Mongolia хөтөлбөрийн нийгэмд үзүүлсэн үр нөлөөг илтгэх тайланг дэлгэн барьж байна. Бид сүүлийн хоёр жилийн хугацаанд зохион байгуулсан үйл ажиллагаа, гарсан үр нөлөөгөө тоймлон хүргэж байгааг хүлээн авна уу.

Бид хөтөлбөрөө 2016 оны 9 дүгээр сард эхэлснээс хойш олон байгууллагатай түншилж, Монгол Улсын цөөнгүй шилдэг, манлайлагч залуустай хамтран ажилласан билээ. Энэхүү хөтөлбөрөөр бид ардчиллын төлөө түүчээлэн ажилладаг монгол залуусын нөөц боломжийг нээн харуулахыг зорьсон төдийгүй LEAD Alliance хөтөлбөрөөр Азийн бусад залуу манлайлагчидтай тэднийг холбох, мөн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн олон мянган сурагчдыг идэвх, оролцоотой иргэд болгон төлөвшүүлэхээр ажилласан юм.

Та энэхүү тайлантай танилцан, LEAD хөтөлбөрийн санаачилсан үйл ажиллагааг дэмжиж, цаашид бидэнтэй хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.



World Learning олон улсын төрийн бус байгууллага нь дэлхийн 60 гаруй оронд боловсрол, тогтвортой хөгжлийн чиглэлээр сургалт, солилцооны хөтөлбөр зохион байгуулан хувь хүн, байгууллагыг чадавхжуулдаг билээ. Манай байгууллага өнгөрсөн 85 жилийн турш дэлхий ертөнцөө илүү амар амгалан, шударга болгохын төлөө ажиллаж ирсэн бөгөөд Монгол Улсад 2002 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн түүхтэй. LEAD Mongolia хөтөлбөр нь америк ард түмний дэмжлэг, Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн тусламжтайгаар 2016 оноос хэрэгжсэн болно.

LEAD Mongolia хөтөлбөрийн тухай

LEAD Mongolia нь 5 жилийн хугацаатай хөтөлбөр бөгөөд залууст иргэний боловсролын агуулга бүхий сургалт, олон улсын солилцооны хөтөлбөрт хамрагдан, манлайлын ур чадвараа хөгжүүлэх төрөл бүрийн боломжийг олгодог юм. Манай хөтөлбөр дараах үндсэн гурван хэсгээс бүрдэнэ.



LEAD Mongolia нь Монгол Улсын төрөл бүрийн салбарт манлайлан ажиллаж байгаа 230 орчим чадварлаг залууст хөтөлбөрт хамрагдан өөр хоорондоо танилцан нөхөрлөх, хүрээгээ тэлэх, нийгэмд тулгамдаад байгаа асуудалд хүчээ нэгтгэн эергээр өөрчлөх боломж олгох зорилго бүхий эрчимжүүлсэн хөтөлбөр юм.



LEAD Alliance нь Монголын залуу манлайлагчдыг ижил үнэт зүйл бүхий үе тэнгийн ази залуустай нэгтгэж, бүсийн хэмжээнд хамтран ажиллах, мөр зэрэгцэн манлайлах нөхцөл бүрдүүлдэг. Үүний зэрэгцээ Монгол Улсын ардчилалд тайван замаар шилжсэн түүх, туршлагыг бусад орны оролцогч залуустай хуваалцах, үлгэрлэх өвөрмөц боломж юм.

Хамтрагч байгууллага:
Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэнгийн Монгол дахь төлөөлөгчийн газар



Ахлах ангийн иргэний боловсролын хөтөлбөр нь хүүхэд залуусыг иргэний амьдралд идэвхтэй, урам зоригтой оролцуулах зорилготой. Суралцаж байгаа сургууль төдийгүй оршин суугаа орон нутгийн нөхцөл байдлаа сайжруулахын тулд сурагчид өөрсдөө үйл ажиллагаа санаачилж, шилдэг санаа төслийг тодруулдаг.

Хамтрагч байгууллага:
Иргэний Боловсролын Төв төрийн бус байгууллага





Яагаад LEAD гэж?

Дэлхий дахинаа Монгол Улсыг 28 жилийн тэртээ ардчилсан тогтолцоонд тайван замаар шилжсэн жишиг оронд тооцдог. Гэтэл залуу үеийг иргэний болон улс төрийн үйл явцаас улам гадуурхаж, тэдний оролцоо сонгуулиас сонгуульд огцом буурсаар иржээ. Хүн амын гуравны нэг нь 15-34 насны иргэдээс бүрддэг орны хувьд дээрх дүр зураг нь ардчилсан тогтолцоонд аюул заналхийлэхүйц үзэгдэл юм.

Өдрөөс өдөрт нэмэгдэж буй ажилгүйдэл, авлига, улс төрийн нөхцөл байдалд сэтгэл хангалуун бус яваа

залуус ирээдүйдээ итгэл алдарч, нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, сайн сайхны төлөөх санаачилгад нэгдэх нь багасаж байна.

Үүнтэй уялдан LEAD Mongolia хөтөлбөр нь өөрчлөлтийг түүчээлэх дараа үеийн манлайлагчдыг бэлтгэх, иргэдийн тэгш эрхийн төлөө тэмцэж, тэдний ирээдүйдээ итгэх итгэлийг нэмэгдүүлэх, Монгол Улс болоод Ази тивд ардчилсан замналын нэгдмэл алсын харааг бүтээх зорилго тавин ажиллаж байна.

LEAD Mongolia

LEAD Mongolia нь ардчиллын төлөө оройлон зүтгэх шинэ үеийн залууст зориулсан хөтөлбөр бөгөөд иргэний боловсролын агуулга бүхий сургалт, олон улсын солилцооны хөтөлбөрт хамруулан, манлайллын үр чадвараа хөгжүүлж, нийгэм, орчноо сайжруулах төсөл хэрэгжүүлэх боломж олгодог. Уг хөтөлбөр нь Монгол Улсын ардчиллын цаашдын хөгжилд хувь нэмрээ оруулах 25-40 насны хэн бүхэнд нээлттэй юм. Хөтөлбөрт таван жилийн хугацаанд нийт 227 залуу манлайлагч хамруулахаас АНУ дахь солилцооны хөтөлбөрт 137, Монгол Улс дахь хөтөлбөрт 90 хүн оролцоно.

LEAD Mongolia нь харилцан адилгүй үзэл бодол, ажил мэргэжил, туулсан туршлага бүхий залуус хамтран ажиллах боломж олгодог. Ийнхүү салбар бүрийн манлайлагчдыг тэгш хүртээмжтэй эерэг өөрчлөлтийн төлөөх нийгмийн хүч болгон нэгтгэсэн нь оновчтой загвар болохоо харуулж байна. Хөтөлбөрийн оролцогч залуус хамтдаа ажилгүйдэл ба ядуурал; байгаль орчин ба хотжилт; авлига ба ил тод байдал гэсэн гурван үндсэн сэдвийн хүрээнд өөрсдөд эн тэргүүнд хамаатай асуудалд шийдэл санал болгон, төсөл санаачлан хэрэгжүүлдэг.



LEAD Mongolia хөтөлбөр тоон үзүүлэлтээр

97

Улаанбаатар хот болон 18 аймгаас 97 залуу оролцсон.

11

Эдгээр залуус нийгэмд эерэг үр нөлөө үзүүлэхүйц 11 төсөл санаачлан хэрэгжүүлсэн.

26

Төсөл хэрэгжүүлэх явцад нийт 26 байгууллагатай түншлэн амжилттай ажилласан.

3,734

Залуусын санаачилсан төслийн үр шимийг нийт 3,734 хүн шууд хүртсэн.

1,384,276

Хэрэгжсэн төслүүд олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, нөлөөлөх аяны хүрээнд нийт 1,384,276 хүнд хүрсэн.

Манай байгууллага Вашингтон хот дахь World Learning-ийн төв, Виржиниагийн Их Сургуулийн Улс Төр Судлалын Төвтэй хамтран LEAD Mongolia хөтөлбөрийнхөө хүрээнд 2016–2018 онд нийт 67 оролцогчийг 2 удаагийн АНУ дахь богино хугацааны эрчимжүүлсэн солилцооны хөтөлбөрт хамруулаад байна. Харин Монгол Улс дахь хөтөлбөрийн хүрээнд эх орондоо ур чадвараа сайжруулах, сэдэвчилсэн байдлаар чадавхжих, туршлага солилцох эрчимжүүлсэн сургалтад 30 залуус оролцсон болно. Дурдсан 2 төрлийн хөтөлбөрийн хүрээнд сургалтын ерөнхий зорилго адил ба үүнд нөлөөллийн аянг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах, зөрчилдөөнийг зохицуулах, өөрчлөлтийг төлөвшүүлэх, хэрэгцээнд суурилсан төсөл санаачлах, хэрэгжүүлэх зэрэг ур чадвар эзэмшүүлэх агуулга багтдаг юм.



Өнөөг хүртэл хөтөлбөрт оролцсон залуус нэгэн дуугаар буюу 100 хувь “Уг хөтөлбөрийн хүрээнд бий болсон харилцаа холбоо, шинэ хүрээлэл нь нийгэмд эерэг нөлөөлөл авчрахад нь тусалж байна” гэж сэтгэгдлээ хуваалцжээ. Энэ нь салбар салбарын манлайлагч залуусыг нэг дор уулзуулж, хамтран ажиллах боломж олгох нь ардчиллыг бэхжүүлж, нийгэмд эерэг өөрчлөлт авчирдаг болохыг харуулж байна. Мөн оролцогчдын

97 хувь “Ардчилсан засаглалд итгэх итгэл улам лавширч, Монгол Улсын ардчиллыг бэхжүүлэхэд өөрийн биеэр хувь нэмрээ оруулах ур чадвартай болж байна” хэмээсэн байна.



“Хамгийн чухал нь би төрөл бүрийн хүмүүстэй ажиллаж сурлаа. Хөтөлбөрөөс олж авсан хамгийн том өгөөж бол янз бүрийн ажил эрхэлдэг, өөр өөр нийгмийн салбар, нас, яс үндэс, шашин шүтлэг, итгэл үнэмшил, хүйсийн чиг баримжаа, нийгэм-эдийн засгийн боломжтой хүмүүс нэгэн зорилгын доор нэгдэж чадсан.” - LEAD Mongolia хөтөлбөрийн оролцогч Б.Тэмүлин

Таван жилийн дараа хөтөлбөр хэрэгжиж дуусахад бид нийгмийн сорилт, бэрхшээлийг сөрөн шийдвэрлэх чадвартай 227 шинэ залуу манлайлагчдын нэгдэл, нөлөө бүхий хүрээг бий болгосон байна. Мөн оролцогчид төрийн бодлогыг улам сайжруулах, нийгэм эергээр өөрчлөхийн төлөө зүтгэх, иргэдийг тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэхэд нь уриалан чиглүүлэх чадавх, мэдлэгийг эзэмшсэн байна.

ТӨСЛИЙН ТУХАЙ

“Бид авлигыг эсэргүүцэх дуу хоолой байхыг хүссэн. Зөвхөн хүүхэд хүүхэддээ хүрэхийг зориогүй. Хүүхдийн зан төлөвшилд шууд нөлөөлдгөөрөө эцэг эхчүүд ч гэсэн энэ санаачилгад оролцоосой гэж бодож байна.” Төсөлд оролцсон сурагч

“Ил тод байдал залуусын нүдээр” төсөл нь LEAD Mongolia хөтөлбөрийн оролцогчдын өнөөдрийг хүртэл хэрэгжүүлсэн 11 төслийн нэг юм.

Өдрөөс өдөрт нэмэгдэж буй авлига, хээл хахуулийн асуудал, ил тод бус байдал нь монголчуудын төр засаг, ардчилсан тогтолцоонд итгэх итгэлийг бууруулж байна. Транспэрэнси Интернэшнл олон улсын байгууллагын гаргасан 2017 оны “Авлигын индекс”-ээс харахад Монгол Улс 100 онооноос 36 оноо аван, 180 орноос 103-т жагссан байгаа нь бүс нутагтаа тун доогуур орох үзүүлэлт юм. Өнгөрсөн 2016 оны судалгаатай харьцуулахад 16 байр хойшилсон нь авлигын гинжин хэлхээнээс ангижрах гэж ядаж буй орны хувьд томоохон ухралт билээ.

Төсөл хэрэгжүүлсэн багийнхны үзэж байгаачлан дийлэнх монголчууд авлигыг нэгэнт амьдралын нэг хэсэг хэмээн хүлээн зөвшөөрч, яаж шийдвэрлэх талаар бодохоо ч больсон нь хамгийн том асуудал аж.

Залуу үеийнхэн бодлого боловсруулах явцад оролцож, дуу хоолойгоо өргөх эрмэлзэлгүй болсон нь ч энэ бүхний үр дагавар гэж хэлж болно.

Харин уг төслийг хэрэгжүүлсэн 11 залуу авлигатай тэмцэх нэгэн гарцыг олж харжээ. Өнгөрөгч оны сүүлээр эхэлсэн “Ил тод байдал залуусын нүдээр” төсөл нь Монгол Улсын хүүхэд залууст ил тод байдал гэж юу болох, яагаад тэдэнд хамаатай болох, авлигатай тэмцэхийн тулд тэд юу хийж чадах талаар мэдээлэл өгөх зорилготой байв. Багийн ахлагч, хуульч М.Мөнхжаргал “Бид залуу үеэсээ л эхлэх ёстой. Дунд сургуулиудын хичээлийн хөтөлбөрт ил тод байдлыг танилцуулсан, сурталчилсан агуулга алга. Авлига авсан албан хаагчийг шийтгэх ёстой гэдгээс өөрөөр авлигатай тэмцэх ойлголт хүмүүст байдаггүй” гэж бидэнд хэлсэн юм.

“Ил тод байдал залуусын нүдээр” төсөл нь дунд сургуулийн ахлах



ангийн сурагчид, их, дээд сургуулийн оюутнуудын оролцоотойгоор ил тод байдал, авлигын тухай сургалтын хөтөлбөрийн агуулга бэлтгэхийг зорьжээ. Нийтдээ 30 сургуулийн төлөөлөл оролцуулсан видео бүтээлийн уралдаан зохион байгуулж, өдөр тутмын авлигын хор уршгийн талаарх залуусын мэдлэгийг нэмэгдүүлэх, тэднийг чадавхжуулах 36 богино хэмжээний видео бүтээлийг хүлээн авсан байна. Эрүүл мэнд, боловсрол зэрэг олон салбарт нүүрлэсэн авлигын талаарх эдгээр бичлэгүүдийг нийт 325,000 хүн цахим орчинд үзэж сонирхжээ. Улмаар төслийн баг уг видео бүтээлүүдээс агуулгаар нь сорыг нь шалгаруулж багш, сурагчидтай хамтран ил тод байдлыг заах сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүн бэлтгэж, нийт 21 аймгийн 778 сургуульд хүргүүлээд байна. Энэ төслийн үр дүнд ахлах ангийн багш сурагчдын гар дээр шинэлэг, ашиглахад хялбар сургалтын материал эцсийн бүтээгдэхүүн болон очсон юм.

LEAD Alliance: Бүс нутгийн залуу манлайлагчдын сүлжээ

LEAD Alliance-ийн үндсэн зорилго нь Монгол Улсын чадамжийг бүрэн нээн хэрэгжүүлэхэд оршино. Хөтөлбөрийн хүрээнд бид Монгол Улсын залуу манлайлагчдыг Киргиз, Бутан, Мьянмар Улсын чадварлаг, ижил үнэт зүйлтэй, үе тэнгийн манлайлагчидтай холбож, тэднийг нэгтгэж, сэдэлжүүлэх, эерэг өөрчлөлтийг авчрах эрмэлзэл төрүүлэх олон үйл ажиллагааг зохион байгуулдаг.

Эдгээр түнш орнууд болон Монгол Улсаас хөтөлбөрт оролцсон залуус хамтдаа LEAD Alliance хэмээх бүсийн залуу манлайлагчдын сүлжээг байгуулаад байна. LEAD Alliance нь жил бүр Киргиз, Бутан, Мьянмар Улсаас 25-40 насны нийт 15 оролцогчийг шалгаруулан хамруулдаг.



LEAD Alliance хөтөлбөр тоон үзүүлэлтээр

35

Нийт 35 оролцогч Киргиз, Бутан, Мьянмар Улсаас хамрагдсан.

95


Монгол, Киргиз, Бутан, Мьянмар Улсын 95 залуу 2017, 2018 онд Улаанбаатар хотноо LEAD Alliance чуулганд оролцсон.

6

Киргиз, Бутан, Мьянмар Улсад нийт 6 нийгэмд чиглэсэн төсөл санаачлан хэрэгжүүлж, 18 удаагийн сургалт, үйл ажиллагаа зохион байгуулсан нь нийт 1,675 иргэнийг хамарсан.

12

Монголоос LEAD Mongolia хөтөлбөрийн 12 оролцогч Бутан, Киргиз, Мьянмар Улсад зочилж, төслийн хэрэгжилтэд зөвлөн, чиглүүлж ажилласнаас гадна Монгол Улсын ардчиллын замналын түүх туршлагаас хуваалцсан.



LEAD Mongolia хөтөлбөрийн манлайлагч залуус маань эдгээр 3 орны залуустай хамтран манлайллын цуврал цахим хэлэлцүүлэг, менторын хөтөлбөр, ажил хэргийн холбоо тогтоох уулзалт, Улаанбаатар хотноо жил дараалан зохион байгуулж буй чуулган зэрэг боломжит бүх арга замаар нягтран ажилладаг.

LEAD Alliance чуулганы хүрээнд 4 орны залуу манлайлагчид нэгэн дээвэр дор хуран цуглаж, алдаа оноо, туулсан туршлагаа хуваалцан, нэг нэгнээсээ суралцахын зэрэгцээ өөр өөрсдийн оронд хэрэгжүүлэх төслүүд дээрээ шууд гар бие оролцон ажилладаг. Дээрх гурван орны манлайлагч залуус, монгол оролцогчидтой хамтран зорьсон үйл хэргээ ажил болгохын тулд бага хэмжээний гарааны санхүүжилт авдаг юм. Мөн Монгол талын шалгарсан оролцогчид зочин орнуудын оролцогчдын төсөлд зөвлөх эрхтэй болдог онцлогтой.

ТӨСЛИЙН ТУХАЙ

“Манлайлал тэгш хүртээмжээс эхэлнэ” төсөл нь LEAD Alliance хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн 6 төслийн нэг билээ.

Киргиз Улсад хөгжлийн бэрхшээлтэй залуусын амьдрал асар их саад, бэрхшээлээр дүүрэн байдаг бөгөөд наад захын үйлчилгээ авах эрх, сурч боловсрох боломж нь хязгаарлагдмал байсаар байна.

“Киргиз Улс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд амьдрахад хамгийн хэцүү орнуудын нэг” гэж LEAD Alliance хөтөлбөрийн оролцогчдын нэг, хүний эрхийн тэмцэгч Дилдора Хамидова дурдсан юм. Тийм ч учраас Дилдора хөтөлбөрийн бусад таван оролцогчийн хамт Киргиз Улсын хөгжлийн бэрхшээлтэй залуу иргэдэд тулгардаг гадуурхал, ялгавартай байдлын эсрэг тэмцэхээр шийджээ. “Манлайлал тэгш хүртээмжээс эхэлнэ” төслийнхөө хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй залуусын ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлэхээр компьютерын сургалт, бусад мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг боловсруулсан байна. Гурван сар хэрэгжсэн уг төслийн хүрээнд Бишкек, Ош хотын 19 хөгжлийн бэрхшээлтэй залууст нэн шаардлагатай дэмжлэгийг үзүүлээд



зогсохгүй, цаашлаад эдгээр залуус нийгмийн харилцаанд орж, өөртөө итгэх итгэл нь нэмэгджээ. Төслийн үр дүнгээс харахад сэтгэл гарган, бодлоготой хандахад тэгш хүртээмжтэй байдлыг хангах бүрэн боломжтой нь харагдсан юм.

Хөтөлбөрийн оролцогч Айнагуль Абдрахмановагийн хэлж байгаагаар Киргиз Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд энгийн бөгөөд хэрэгцээт үйлчилгээ авах, сурч боловсрох боломж нь хаагдмал байдаг ажээ.

“ Эрх нь удаа дараа зөрчигддөг болохоор эдгээр хүүхдүүд хамгийн эмзэг бүлгийнхэн юм. Тэдэнд чанартай боловсрол эзэмших, эрүүл мэндийн үйлчилгээ авах, ажил эрхлэх боломж нь алга.”
- LEAD Alliance хөтөлбөрийн оролцогч Айнагуль Абдрахманова



LEAD Mongolia хөтөлбөрийн оролцогч М.Золжаргал, Ш.Венера нар дээрх төслийн зөвлөхөөр сонгогдон 2018 оны 3 дугаар сард Киргиз багийн төслийн хэрэгжилтэд зөвлөх, дэмжлэг үзүүлэх, чиглүүлэх үүрэг тээн Киргиз улсыг зорьсон билээ. Төсөлд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй залуус дутагдаад байсан мэдлэг, чадвараа олж аваад зогсохгүй хоорондоо нөхөрлөн, нийгэмшиж, сэтгэл өндөр байсныг зөвлөхөөр

ажилласан хоёр маань дурдаж байлаа. Төслийн хэрэгжилт сайн, хөтөлбөр нь шинэлэг байсан ч монгол оролцогчид маань төслийн багт нэмэлт санаа, сайжруулах зөвлөмж өгч ажилласны сацуу Монгол Улсын ардчилсан замнал, иргэдийн оролцоо, улс төрийн эрх чөлөө бүс нутагтаа яагаад жишиг гэдгийг ч эргэцүүлж, ойлгосон юм. М.Золжаргал, Ш.Венера нарын энэ жишээ LEAD Alliance хөтөлбөрийн хүрээнд бүс нутагт хэрэгжиж буй

төслүүдэд зөвлөхөөр шалгарч ажилласан 12 монгол оролцогчийн аялж, ажилласан түүхийн ердөө нэг нь билээ. Мьянмар дахь иргэдийг чадавхжуулах төсөл, Бутаны аглаг хөдөөгийн онгон байгалийг цэвэрлэх байгаль орчны төсөл гэх мэт олон шинэлэг төсөл дээр монгол залуус маань зөвлөж, төслийн үр дүн хэдэн мянган хүнд үр өгөөжөө өгсөний сацуу Монгол орны ардчиллын замналын түүх, амжилт, жишгээс хуваалцсан юм.

Ахлах ангийн иргэний боловсрол

Монголын шинэ үеийн залуус ардчиллын үнэ цэнд эргэлзэж буй энэ цаг үед иргэний боловсролын ач холбогдол нэн чухал. Иргэний боловсрол дунд сургуулийн ахлах ангийн зайлшгүй орох сургалтын хөтөлбөрт багтаагүй бөгөөд багш нар ч энэ сэдвийг заах хангалттай аргачлал олгох сургалтад хамрагдаагүй байдаг.

LEAD хөтөлбөрийн хүрээнд ахлах ангийн монгол сурагчдад зориулсан иргэний боловсролын тусгай хөтөлбөр, сурах бичиг боловсруулан, хичээлд нь ашиглахаас гадна сурагчдыг орчин тойрондоо тулгарсан асуудлаа шийдвэрлэх чадвартай, оролцоотой иргэд болгох зорилготойгоор хичээлээс гадуурх олон нийтийн ажлуудад оролцуулж байна.

LEAD хөтөлбөрийн хүрээнд бид дунд сургуулийн ахлах ангийн сурагчдад зориулан 4 хэсгээс бүрдэх “Ардчиллын үндэс” иргэний

боловсролын сурах бичгийг бэлтгэн гаргасан юм. Бид 2016 оноос хойш Монгол орны өнцөг булан бүрийн 242 дунд сургуулийн 428 багшийг энэхүү сурах бичгийг ашиглан

иргэний боловсрол олгох арга зүйн сургалтад хамруулаад байна. Мөн уг сурах бичгийг 2,100 хувь хэвлэн сургуулиудад хүргүүлжээ.



Ахлах ангийн иргэний боловсрол тоон үзүүлэлтээр

458

242 дунд сургуулийн 458 багш “Ардчиллын үндэс” сурах бичгийг ашиглан иргэний боловсрол олгох арга зүйн сургалтад хамруулсан.

2,981

Нийт 11 аймгийн 70 дунд сургуулийн 2,981 сурагч “Иргэн төсөл”-д оролцсон.

2,100

2,100 ширхэг “Ардчиллын үндэс” ном Монгол орны өнцөг булан бүрийн 242 сургуульд хүргэсэн.

Түүнээс гадна дэлхийн 60 гаруй оронд ашигладаг “Иргэн төсөл” нэртэй оролцоонд суурилсан аргачлалыг нэвтрүүлэв. Уг аргачлал нь сурагчдад өөрсдийн орчин тойронд тулгарсан асуудлаа тодорхойлох, шийдвэрлэх, сайжруулах санал санаачилга дэвшүүлэх, улмаар шийдвэр гарган өөрчлөх чадваруудыг олгодог.



“Иргэн төсөл”-д нийт 11 аймгийн 70 сургуулиас 140 багш, 2,981 сурагч хамрагджээ. 2018 оны 3 дугаар сард Улаанбаатар хотноо анх удаагаа “Иргэн төсөл”-ийг үндэсний хэмжээнд шалгаруулж, хот, орон нутгийн нийт 12 баг сургууль болон нийгэмдээ авчирч байгаа эерэг өөрчлөлт, шийдлээрээ өрсөлдсөн билээ.

Хөтөлбөрийн “Ардчиллын үндэс” сурах бичиг, “Иргэн төсөл” аргачлал нь нийгмийн ухааны

багш нарт оролцоотой иргэдийг бэлдэх заах арга зүйг олгох зорилготой. Бид дараагийн ээлжид “Ардчиллын үндэс” сурах бичгийг нэмж хэвлүүлэх, мөн ахин 100 дунд сургуулийн багш нарыг сургалтад хамруулж арга зүйг нь дээшлүүлэх зорилт тавин ажиллаж байна. Үүнээс гадна “Иргэн төсөл” улсын уралдааныг уламжлал болгон зохион байгуулж, нийгэмдээ тулгарсан асуудлыг шийдвэрлэх санаачилгатай зуу, зуун хүүхэд залуусыг дэмжиж ажиллах болно.

ТӨСЛИЙН ТУХАЙ

Идэвхжсэн сурагчид: Орчноо өөрчлөн сайжруулах чадавх

Улаанбаатар хотын 29 дүгээр тусгай дунд сургууль нь сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан улсдаа цорын ганц тусгай сургууль юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан хичээлийн агуулга, хөтөлбөр Монгол Улсын боловсролын бодлогод цогцоор тусгаагүйн улмаас шаардлагатай хөрөнгө, санхүүгийн бэрхшээл тус сургуулийнханд үргэлж тулгардаг. Тус сургуулийн 20 сурагч “Иргэн төсөл”-д оролцсоноор чанартай боловсрол эзэмших эрхийнхээ төлөө сурагчид өөрсдөө чадавхжин, асуудлыг өөрчлөхөөр нөлөөлж эхлээд байна.

Тус сургуулийн багш, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн төлөө тэмцэгч Б.Туул иргэний оролцоог ахлах ангийн сургагчдад заах арга зүйг LEAD Mongolia хөтөлбөрийн сургалтаас авч, “Иргэн төсөл”-д сурагчдынхаа хамт нэгджээ. Багш, сурагчид тулгарч



буй асуудлаа хамтын хүчээр шийдвэрлэх зорилготой “Иргэн төсөл”-ийн хүрээнд тэд эхний ээлжинд сургуулийнхаа хамгийн тулгамдсан асуудлуудыг эрэмбэлэн тодорхойлох нэгдсэн судалгаа явуулсан байна. Тулгамдсан асуудлуудын нэг нь “Тус сургуулийн хичээл хоорондын завсарлагааны дохио нь хонх” гэж гарчээ. Гэтэл уг сургуулийн сурагчид сонсголын бэрхшээлтэй тул хонхыг сонсож чадахгүй.

Төслийн багийнхан асуудлаа тодорхойлмогц өөрсдийн эрх, үүрэг, нөөц бололцоогоо судалсан. Мөн тодорхойлон гаргасан асуудлаа шийдвэрлүүлэхийн тулд олон нийтийн дэмжлэгийг авч, шийдвэр гаргагчид, олон улсын байгууллагуудтай ч уулзаж амжсан байна.

Тэдний асуудлыг шийдвэрлэх санаачилга үр дүнд хүрч, 29 дүгээр сургуулийн завсарлагааны

хонхыг анивчдаг гэрлээр солихоор болсон юм. Ийнхүү сурагчид хичээлээс хоцрох зэрэг асуудал буурахаас гадна аюул осол, онцгой байдлын дохио өгөхөд сурагчид мэдэхгүй өнгөрөх эрсдэлгүй болжээ. Уг гэрлэн төхөөрөмжийг суурилуулахад шаардлагатай 10 сая төгрөгийг Б.Туул багш, түүний сурагчид Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас санхүүжилтийг хүсэж, гаргуулахаар болсон байна. Хийсэн ажлынхаа хүрээнд тэд мөн Ийгл телевизийн нэвтрүүлэгт оролцож хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тулгардаг бэрхшээлийг нийт монголчуудын сонорт хүргэж чаджээ. “Иргэн төсөл” байгаагүй бол уг асуудал шийдэгдэхгүй байх байсан. Сурагчид маань одоо сургуульдаа болон нийгэмдээ өөрчлөлт авчрах хэмжээнд чадавхжсан нь маш авуштай” хэмээн Б.Туул багш бидэнд хэлсэн юм.



Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга 2018 оны “Иргэн төсөл”-ийн үндэсний хэмжээний шалгаруулалт дээр эдгээр санаачилгыг ийнхүү онцлон сайшаасан билээ.

“Сурагчид өөрсдөд тулгарсан асуудлаа бодит судалгаа, жишээтэй гаргаж ирэн, тохирсон шийдлийг хууль эрхзүйн гаргалгаатай нь дэвшүүлж, шийдвэр гаргагчдад танилцуулж байгаа нь энэ төслийн онцлог юм. Цаашид ч ийм санаачилга олон байгаасай.”

Бидний эрхэмлэдэг зарчмууд

World Learning хэрэгжүүлж буй бүх хөтөлбөртөө дараах зарчмуудыг удирдлага болгодог ба нийт оролцогч нартаа эдгээр зарчмыг эрхэмлэхийг хөхиүлэн дэмждэг.

ОЛОН ЯНЗАТ БАЙХ

Оролцогчдын дунд бүтээлч, үр өгөөжтэй харилцаа, нэгдлийг бэхжүүлэхийн тулд хөтөлбөрт оролцогч болгон төрөл бүрийн үр чадвартай, салбар мэргэжлийн, өөр өөрийн сонирхол, нийгмийн шинжийг харуулсан олон янзтай байж болохыг дэмжих, зоригжуулах.

НИЙГЭМДЭЭ ТЭГШ ХАМРУУЛАХ

Өөрийн амин чанараас үүдэлтэй гадуурхагдсан хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэхийн тулд тэдэнд чадвар, боломж олгох, эрхэм чанарыг өргөх.

ОРОЛЦОГЧ ӨӨРСДӨӨ ЗАЛАХ

Хөтөлбөрөөс олж авах туршлага, агуулгаа оролцогч өөрөө шийдвэрлэхийг дэмжих, зоригжуулах.

ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ӨӨРСДӨӨ ЗАЛАХ

Тухайн зон олонд хүрэх үр нөлөөтэй арга зам зэрэг хөтөлбөр загварчлах, боловсруулах тухай мэдүүлэхийн тулд орон нутгийн оролцогч талуудыг урих.

ЗАЛУУСЫГ ОРОЛЦУУЛАХ

Залуусын асуудалд залуус өөрсдөө дуу хоолойгоо хүргэх боломжоор хангах.

ЖИНХЭНЭЭСЭЭ МАНЛАЙЛАХ

Бүх нийтийн ашиг сонирхлыг эрхэмлэн, бусдын төлөө болон бүгдийг тэгш хамруулахыг эрмэлзэж, шийдвэр гаргах чадвар, хуурмаг төрхгүй манлайлагчдыг төрүүлэх

ТУРШЛАГА ТУУЛЖ, СУРАЛЦАХ

Шинэ санаа, мэдлэг, үр чадварыг төсөл төлөвлөх, хэрэгжүүлэх, нөлөөлөх, орон нутгийн санаачилгад өрнүүлэхдээ бодит ажил болгон хэрэгжүүлэх.

НӨЛӨӨЛӨХИЙН ТУЛД САЛБАР ХООРОНД УЯЛДАЖ АЖИЛЛАХ

Ардчилсан, сайн засаглалын суурийг дан ганц төр хүлээх үүрэгтэй бус, хүн нэг бүрээс хамааралтай хэмээх цогц байдлаар нийгмээ харах ёстойг оролцогчдод бататган ойлгуулж, салбар хооронд буюу төр, хувийн хэвшил, иргэний нийгэм хамтардаг хандлага суулгах.

LEAD Цаашдаа

LEAD Хөтөлбөрийн эхний 2 жилд гарсан амжилт, үр нөлөөг үндэслэн манай хөтөлбөр дахин 3 жил үргэлжлэхээр болсон сайхан мэдээг та бүхэнд дуулгахдаа баяртай байна. Ийнхүү бид ардчиллын дуу хоолой болсон залуусын хүчирхэг нэгдлийг Монгол Улс болоод бүс нутагт өргөжүүлэн ажиллахаар боллоо. Дараагийн гурван жилийн хугацаанд LEAD Mongolia хөтөлбөрийн хүрээнд 130 монгол залуу, LEAD Alliance хөтөлбөрийн хүрээнд Бутан, Киргиз, Мьянмар улсаас 30 залуу сонгон шалгаруулахаас гадна Монгол орны өнцөг булан бүрийн ЕБС-ийн ахлах ангийн олон мянган сурагчдад иргэний боловсролын хөтөлбөрөө түгээх болно. Манай хөтөлбөрийн төгсөгчдийн хувьд ч аялал нь энэ хүрээд дуусахгүй. Ирэх жилүүдэд хөтөлбөрийн шинэ элсэгчид, төгсөгчид хамтран, ардчиллыг түүчээлэх олон ажил хийнэ гэдэгт бид итгэлтэй байна. Тэд хамтдаа нийгэмдээ эергээр нөлөөлөн, өөрчлөх нь дамжиггүй.

LEAD-тэй хамтрах

Та болон танай байгууллага нийгэмд эерэг өөрчлөлт авчирч буй манай залуусын төсөл, үйл ажиллагаанд хамтран, тэдний хэрэгжүүлэх төслийг ивээн тэтгэн дэмжсэнээр байгууллагынхаа нийгмийн хариуцлага, байгаль орчин, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх боломжтой юм. Эдгээр төслийг хэрэгжүүлэх, гүйцэтгэх, удирдах үйл явцыг олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арвин туршлага бүхий World Learning байгууллага хянан ажиллана.


Та мөн манай оролцогчдод төслөө төлөвлөхөд нь мэдлэг туршлагаа хуваалцан, зөвлөж, хамтран ажиллах боломжтой. Эдгээр болон бусад боломжийн тухай, мөн манай үйл ажиллагааны талаар нэмэлт мэдээлэл авах бол бидэнтэй холбоо барина уу.



ТАЛАРХАЛ

LEAD хөтөлбөр хэрэгжихэд хувь нэмрээ оруулсан хүн бүхэнд талархлаа илэрхийлье. Манай хөтөлбөрийг өнөөг хүртэл дэмжиж ирсэн Монгол Улсын төр, хувийн хэвшлийн байгууллагуудад талархаж байна. Тэр дундаа Монгол Улсын Засгийн Газар, Нийгэм Хамгаалал, Хөдөлмөрийн Яам, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газарт онцгойлон талархал илэрхийлье. Мөн тэгш, хүртээмжтэй ардчилсан хөгжлийн төлөөх үзэл баримтлалдаа үнэнч үлдэхэд тусалж, зөвлөдөг Монгол Улсын иргэний нийгмийн нөхөд, хамтрагчиддаа баярлалаа. Эцэст нь манай хөтөлбөрийг санхүүжүүлэгч Америкийн Нэгдсэн Улсын Засгийн Газрын Хөгжлийн Агентлаг болон Улаанбаатар хот дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яаманд гүнээ талархаж байна.





📍 World Learning - Mongolia
Реженси Резидэнс, 201 тоот
Сүхбаатар дүүрэг-1, ЮНЕСКО-ийн гудамж,
Улаанбаатар хот, Монгол Улс

☎ +976 7701-5161
📘 LEADMongolia
📧 MongoliaLeads
✉ LEADMongolia@worldlearning.org

World Learning-ийн дэлхий даяарх үйл ажиллагаатай дараах хаягаар танилцана уу www.worldlearning.org